

БАТЛАВ
ЁС ЗҮЙН ХОРООНЫ АЖЛЫН
АЛБАНЫ ДАРГА
Н.ГАНБААТАР
2026 оны 1 дугаар сарын 09-ны өдөр

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ, СЭДЭВЧИЛСЭН КОНТЕНТ
БЭЛТГЭХ, ТҮГЭЭХ АЖЛЫН ДААЛГАВАР**

Ажлын нэр: “Төрийн албан хаагчийн ёс зүй, үүрэг, хариуцлага” телевизийн нэвтрүүлэг, контент

Зорилго: Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр таниулах, төрийн байгууллагын ёс зүйн соёлыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Үндэслэл	<p>Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр бүлгийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилго 5, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр болон холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хүрээнд төрийн албан хаагчдын дунд:</p> <ul style="list-style-type: none">- Ёс суртахуун- Ёс зүйн манлайлал- Шударга ёс- Ёс зүйн хариуцлага- Төрийн байгууллагын соёл зэрэг үнэт зүйлсийг төлөвшүүлэх шаардлага нэмэгдэж байна.
Судлагдсан байдал	Төрийн албан дахь ёс зүйн асуудал ба зөрчлийн талаарх олон нийтийн санаа бодлыг тандах судалгааг 2025 онд хийсэн.
Хамрах хүрээ	<ul style="list-style-type: none">- Төрийн албан хаагч нар- УИХ-ын гишүүд, улс төрийн албан тушаалтнууд- Орон нутгийн удирдлагын байгууллагууд- Олон нийт, иргэд, залуучууд- Сэтгүүлч, судлаач, иргэний нийгмийн байгууллагууд
Цар хүрээ	<p>Энэхүү контент нь телевиз болон цахим платформд түгээгдэх бөгөөд контент дараах бүтэцтэй байна.</p> <ul style="list-style-type: none">- Телевизийн нэвтрүүлэг (20 мин)- Богино хэмжээний контент (30-60 сек, 1-3 мин)- Сурталчилгааны трейлер (15-30 сек)- Инфографик, тайлбар видео (motion graphic) <p>Оролцогч талууд:</p> <ol style="list-style-type: none">1. Гол оролцогч: Ёс зүйн хорооны 9 гишүүн (ярилцлага, тайлбар, дүгнэлт өгөх)

	<p>2. Тусгай оролцогч:</p> <ul style="list-style-type: none"> - УИХ-ын зарим гишүүд (хууль тогтоомжийн зорилго, хэрэгжилтийн бодлогын байр суурь) - Төрийн захиргааны болон тусгай албан хаагчдын төлөөлөл - Иргэний нийгмийн байгууллага, судлаач, хуульч (шаардлагатай тохиолдолд) - Иргэдийн төлөөлөл (социал судалгаа, санал асуулга хэлбэрээр)
<p>Гүйцэтгэгчид тавих шаардлага</p>	<p>Гүйцэтгэгч:</p> <ul style="list-style-type: none"> - Салбартаа 2-оос дээш жил үйл ажиллагаа явуулсан байх - Байгууллагын гэрчилгээний хуулбар - Төрийн албаны болон хөдөлмөрийн хууль тогтоомжийн чиглэлээр контент үйлдвэрлэлийн туршлагатайг баталсан хийж гүйцэтгэсэн, ажил хүлээлцсэн ажлын танилцуулга - Анимейшн, жүжигчилсэн контент хийх чадвартай - Сошиал түгээлтийн туршлагатай - Хууль сурталчлах хүрээнд төрийн байгууллагатай хамтран ажилласан жагсаалт. <p>Хүний нөөц:</p> <ol style="list-style-type: none"> 1. Найруулагч: <ul style="list-style-type: none"> - Хүний тоо: 1 - Мэргэжлийн болон төрийн албаны болон хөдөлмөрийн хууль тогтоомжийн чиглэлээр контент үйлдвэрлэлийн контент ажилласан туршлага: 2 ба түүнээс дээш жил - Мэргэжил: Найруулагч - Мэргэжлийн дипломын хуулбар 2. График дизайнер: <ul style="list-style-type: none"> - Хүний тоо: 1 - Мэргэжлээрээ ажилласан туршлага: 2 ба түүнээс дээш жил - Мэргэжил: График дизайнер - Мэргэжлийн дипломын хуулбар. <p>Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: Видео бичлэг хийхэд шаардлагатай мэргэжлийн тоног төхөөрөмжтэй байх.</p>
<p>Гүйцэтгэх ажлын төлөвлөгөө</p>	<p>Гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоногт багтаан ажлын төлөвлөгөө, хуваарь, үе шат, гүйцэтгэх ажлын удирдамж, мэдээлэл цуглуулах арга хэлбэр, тоон судалгааны арга зүй, түүврийн дизайн, асуулга болон фокус бүлгийн ярилцлагын асуулт боловсруулж, захиалагч талд танилцуулж батлуулна.</p> <ul style="list-style-type: none"> - Үндсэн санаа, үзэл баримтлал боловсруулах: 5 хоног - Зохиол бичих: 7 хоног - Зураг авалт/анимейшн: 12 хоног - Эвлүүлэг, пост продакшн: 6 хоног <p>Нийт хугацаа: 30 хоног</p>
<p>Санхүүжилт, гэрээ</p>	<p>Гэрээ байгуулах хэлбэр:</p> <ul style="list-style-type: none"> - Шууд гэрээ <p>Санхүүжилтийн хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> - 20 сая хүртэл

Тайлангийн хуваарь	<p>Гэрээ байгуулж ажил эхэлснээс хойш хуанлийн 12 хоног тутамд ажлын явц, үр дүнг тайлагнана.</p> <p>Ёс зүйн хорооны Ажлын албаны холбогдох ажилтнуудтай нягт хамтран ажиллах бөгөөд үйл ажиллагаагаа тус Ажлын албаны даргад тайлагнаж ажиллана.</p> <p>Гэрээнд заасан хуанлийн үлдсэн 18 хоногт захиалгат ажлыг хийж дуусган, захиалагч талд бүрэн хүлээлгэж өгнө.</p>
Тайланд тавигдах шаардлага	<p>Контент дараах шалгуурыг хангана:</p> <ul style="list-style-type: none"> - Хууль зүйн тайлбар алдаагүй байх - Хэл найруулга олон нийтэд ойлгомжтой байх - Төрийн байгууллагын нэр хүндийг хамгаалсан байх - Улс төрийн сурталчилгааны өнгө аясгүй, төвийг сахисан байх - Иргэдийн итгэл, зөв хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн байх - Ёс зүйн асуудлыг сонирхолтой, бодит жишээгээр хүргэх
Хүлээгдэж буй үр дүн, бүтээгдэхүүн	<ol style="list-style-type: none"> 1. Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн талаарх олон нийтийн ойлголт нэмэгдэнэ. 2. Ашиг сонирхлын зөрчил, хариуцлагын талаарх мэдлэг дээшилнэ. 3. Төрийн байгууллагын ёс зүйн соёл, сахилга хариуцлагын тухай нийгмийн хүлээлт тодорхой болно. 4. Ёс зүйн хорооны үйл ажиллагааны ил тод байдал, нэр хүнд өснө. 5. Ёс зүйн боловсролын контентын сан бий болно.
Байршил, хугацаа:	Улаанбаатар хот, хөдөө орон нутагт, хугацаа 30 хоног.

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЭРЧИМЖҮҮЛЭХ, СЭДЭВЧИЛСЭН КОНТЕНТ
БЭЛТГЭХ, ТҮГЭЭХ АЖЛЫН ДААЛГАВАРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Үйл ажиллагаа	IV/13	IV/14	IV/15	IV/16	IV/17	V/17
1	Санал хүргүүлэх						
2	Байгууллагуудаас ирүүлсэн саналыг хүлээн авах						
3	Ирүүлсэн саналыг шалгаруулах						
4	Гэрээ байгуулах						
5	Ажлын биелэлтийг хүлээн авах						